



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 631

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2, 4.3, 4.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар (Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багц) санхүүжүүлж бий болсон 936,756,376.00 (есөн зуун гучин зургаан сая долоон зуун тавин зургаан мянга гурван зуун далан зургаан) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Сүхбаатар аймгийн Мал эмнэлгийн газрын хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Батчулуун, Сүхбаатар аймгийн Мал эмнэлгийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Молорчимэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан хөрөнгийг хүлээлцэх, бүртгэх;

2.4. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.5. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

133003992
31-r huraldaan

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 03 дүгээр сарын 12 ны өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ /ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН БАГЦ/-ААР БАРЬСАН
СҮХБААТАР АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ
/БАРИЛГА БАЙГУУЛАМЖ/

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Төсөл, арга хэмжээний хүчин чадал	Гүйцэтгэлээрх хөрөнгийн дүн	Улсын комиссын акт		Ашиглагч байгууллага
				Огноо	Дугаар	
1	"Мал эмнэлгийн хяналт, ариутгалын пункт" барилга (Сүхбаатар аймаг Баруун-Урт сумын 1-р баг)	мал эмнэлгийн ариутгалын зориулалттай, дунд ангилалын, зоорьгүй, 1 давхар А блок 24x14м, Б блок 24x10м барилга,	936,756,376.00	2021.11.17	СҮ-016/21	Сүхбаатар аймгийн мал эмнэлгийн газар (Сүхбаатар аймаг, Баруун-урт сум)
НИЙТ ДҮН			936,756,376.00			
			(есөн зуун гучин зургаан сая долоон зуун тавин зургаан мянга гурван зуун далан зургаан төгрөг)			